



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 12 сарын 03 өдөр

Дугаар А/748

Хууд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ийн "а", 29.1.6-ийн "а" дахь заалтыг тус тус заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Бэлчээр ашиглалтыг сайжруулах" дэд хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэгч байгууллагуудтай хамтран "Байгальд ээлтэй малчин өрх", "Байгальд ээлтэй малчдын бүлэг" шалгаруулах журмыг боловсруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн

дарга: Б.Бямбажав - Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга

Гишүүд: Д.Цэвээнравдан - Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хүнс, хөдөө аж ахуй, байгаль орчны хорооны дарга /Зөвшилцсөнөөр/

Л.Батбаяр - Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга

Ц.Пүрэвсүрэн - Аймгийн Засаг даргын тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

Г.Бат-Өлзий - Хүнс, хөдөө аж ахуйн газрын мал үржлийн албаны дарга

Э.Галбадрах - Дэлхийн байгаль хамгаалах сангийн Алтай соёны бүсийн мэдээлэл харилцааны ажилтан

Д.Дарьханд - "Си си эй пи" төслийн Ховд аймгийн зохицуулагч

А.Отгонбаяр - Бэлчээрийн холбооны зохицуулагч

Нарийн бичгийн

дарга: Э.Гансүх - Хүнс, хөдөө аж ахуйн газрын мэргэжилтэн

2. “Байгальд ээлтэй малчин өрх”, “Байгальд ээлтэй малчдын бүлэг” шалгаруулах журмыг боловсруулан аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээр 2021 оны 12 дугаар сарын 20-ны дотор багтаан батлуулахыг ажлын хэсгийн ахлагч /Б.Бямбажав/, ажлын хэсгийн гишүүдэд даалгасугай.

3. Батлагдсан хөтөлбөрийг сум орон нутаг, иргэд олон нийтэд сурталчлан таниулж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газар, төсөл хөтөлбөрийн байгууллагуудад үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ



Т.ЖАРГАЛСАЙХАН